



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 230

Мандалговь

Хөрөнгө балансаас баланст  
шилжүүлэх тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


Нэг. Дундговь аймгийн ХХААЖДҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй УБХ 0641 улсын бүртгэлтэй 17'714'700 /арван долоон сая долоон зуун арван дөрвөн мянга долоон зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, үлдэгдэл өртөггүй Land Cruiser Prado 75 маркын автомашиныг Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн албаны үндсэн хөрөнгөнд балансаас баланст шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Автомашиныг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дундговь аймгийн ХХААЖДҮГ-ын дарга /М.Мөнхжаргал/-д, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж авахыг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Очирбат/ нарт тус тус даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



1100000529

### Автомашин хүлээлцсэн акт

2014.01.03

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 12 сарын 30-ны өдрийн “Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 230 тоот тогтоолын дагуу ХХААЖДҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, УБМ 06-41 улсын дугаартай Prado 75 маркын машиныг ХХААЖДҮГ-ын дарга М.Мөнхжаргал, жолооч С.Цолмонбаяр, ОНӨАлбаны дарга П.Очирбат, жолооч М.Хүрэлбаатар нар байлцан хүлээлцэв.

Автомашины шинж тэмдэг, үзүүлэлт:

1. Гэрэл дохио бүрэн ажиллаж байгаа
2. Асалт хэвийн
3. Автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бичиг баримт бүрэн
4. 2013 онд үзлэгт ороогүй
5. Өнгө үзэмж, гадна тал хэвийн
6. Км-ын заалт 170469 /ажиллахгүй/
7. 4 дугуй халзан, муу
8. Урд хойд гупр халцархай, сэвтэй
9. Зөв талын хаалга халцархай, сэвтэй
10. Зөв урд талын кирло сэвтэй, будаг халцархай
11. Ар талын шил хагархай
12. Арын 2 хаалганы усны хамгаалалт байхгүй
13. Аккумулятор байхгүй
14. Мотор болон бөгснөөс тос гарсан
15. Ачмагны урд тал хугархай

Хүлээлгэн өгсөн: ХХААЖДҮГ-ын дарга

Жолооч:



/М.Мөнхжаргал/

/С.Цолмонбаяр/

Хүлээн авсан: ОНӨАлбаны дарга:

Жолооч:



/П.Очирбат/

/М.Хүрэлбаатар/